



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/25

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулий 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/09 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд 8500 метр квадрат газрыг аймгийн Засаг даргын Тамгын газар /9067043/-т кино театрын зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд 3000 метр квадрат газрыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /9067841/-т төрийн захиргааны байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд 30000 метр квадрат газрыг аймгийн Засаг даргын Тамгын газар /9067043/-т олон угсаатны театрын зориулалтаар 15 жилийн хугацаагаар,


4. Жаргалант сумын Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд 1500 метр квадрат газрыг аймгийн Гадаадын иргэн, харьяатын газар баруун бүс дэх газар /4081676/-т төрийн захиргааны байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

5. Жаргалант сумын Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд 5000 метр квадрат газрыг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар /9068015/-т цэцэрлэгийн зориулалтаар 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 07 дүгээр сарын 06-ны өдрийн А/331 дүгээр захирамж, Засаг даргын 2021 оны 07 дүгээр сарын 06-ны өдрийн А/332 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7. Газар эзэмших эрх нь баталгаажсан байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГДАРГА



Б.ДУГЭРЖАВ